



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумын төвийн цахилгааны шугамыг СИП кабелиар солих” төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 314,919,567.00 (гурван зуун арван дөрвөн сая есөн зуун арван есөн мянга таван зуун жаран долоон) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

"УВС ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Материалын нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж өртөг (төгрөг)	Бүгд өртөг (төгрөг)	Шингэсэн өртөг (төгрөг)		Нийт дүн (төгрөг)
						Нэгж	Бүгд	
1	Төмөр бетон тулгуур 9м /УКШ9- 27.15/	ш	233	320,000.00	74,560,000.00	622,106.85	144,950,895.58	144,950,895.58
2	Татагч /РА-1500/	ш	154	8,500.00	1,309,000.00	16,524.71	2,544,805.83	2,544,805.83
3	Баригч	ш	170	5,500.00	935,000.00	10,692.46	1,817,718.45	1,817,718.45
4	Фазын салбарлагч /ТТД-181/	ш	212	8,500.00	1,802,000.00	16,524.71	3,503,239.19	3,503,239.19
5	СИП кабель /СИП 3*50+1*54/	м	7630	6,800.00	51,884,000.00	13,219.77	100,866,849.07	100,866,849.07
6	Буултын угас /ф8/	м	577	3,500.00	2,019,500.00	6,804.29	3,926,077.44	3,926,077.44
7	Тулаас тогтоогч, хязгаарлагч, бүслүүр	ком	70	37,000.00	2,590,000.00	71,931.10	5,035,177.30	5,035,177.30
8	Тоолуурын хайрцаг /3-тай/	ком	67	323,000.00	21,641,000.00	326,680.00	21,887,558.00	21,887,558.00
9	Тоолуурын хайрцаг /6-тай/	ком	5	585,000.00	2,925,000.00	619,687.42	3,098,437.09	3,098,437.09
10	Тарифт тоолуур /DDS155 /	ш	230	84,750.00	19,492,500.00	89,775.23	20,648,302.52	20,648,302.52
11	Шит тогтоогч /ф220/	ш	96	17,000.00	1,632,000.00	18,008.01	1,728,769.00	1,728,769.00
12	Салбарлагч /ТТД 101/	ш	288	8,500.00	2,448,000.00	9,004.01	2,593,153.50	2,593,153.50

13	Буултын угас /3*16+1*10/	м	576	3,800.00	2,188,800.00	4,025.32	2,318,584.31	2,318,584.31
Нийт дүн								314,919,567.00
		(гурван зуун арван дөрвөн сая есөн зуун арван есөн мянга таван зуун жаран Доллоо)						